



**НАЛАЙХЫН БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН  
ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨААТҮГ  
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 10 сарын 24 өдөр

Дугаар А/47

Улаанбаатар хот

Баримт бичиг нягтлан шалгах комиссын  
бүрэлдэхүүн, дүрмийг шинэчлэн  
батлах тухай

Үндэсний архивын газрын даргын 2007 оны 59 дүгээр тушаалаар батлагдсан “Байгууллагын архивын ажлын үндсэн заавар”-ын 2.2.2, 2.2.3, 2.2.4 дахь “Налайх барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дүрмийн 5.1.8 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Баримт бичиг нягтлан шалгах комиссын бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, баримт бичиг нягтлан шалгах комиссын дүрмийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2. Байгууллагын архивын үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомж, тэдгээрт нийцүүлэн гаргасан эрх зүйн акт, дүрэм журам, заавар, стандартын хэрэгжилтэд дүгнэлт хийж, байгууллагын хэмжээнд зөвлөмж өгөх, үйл ажиллагааг сайжруулах талаар дэмжлэг үзүүлж, хяналт тавин ажиллахыг комиссын дарга /Н.Пүрэвсүрэн/-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан газрын даргын 2019 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн А/26 тоот тушаалыг хүчингүйд тооцсугай.

ДАРГА  С. БАТЖАРГАЛ

УЛААНБААТАР ХОТ  
НАЛАЙХЫН БАРИЛГЫН  
ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК  
ОНӨААТҮГ  
ТТБ8651 ☎ 5890683